

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Бодлогын баримт бичигт тусгагдсан болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангуулах					
Үндсэн чиг үүрэг-1: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох					
Зорилт 1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.	Арга хэмжээ 1. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулсан хувь	2020 онд 53 хувь	2021 онд 54.5 хувь; 2022 онд 56 хувь; 2023 онд 57.5 хувь; 2024 онд 59 хувь.	Улсын төсөв 2,200.0 сая төгрөг
	Арга хэмжээ 2. Сумдад орон тооны биеийн тамирын арга зүйчийг үе шаттай ажиллуулж эхлүүлнэ.	Сумын биеийн тамирын арга зүйчийн тоо	2020 онд 60 биеийн тамирын арга зүйч суманд ажиллаж байна.	2022 онд 110; 2023 онд 200; 2024 онд 330 арга зүйч.	Улсын төсөв 2,553.1 сая төгрөг
	Арга хэмжээ 3. Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, платформ бий болгож хэрэгжүүлнэ.	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа эхэлж, 3 ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болох	2020 онд ТЭЗҮ хийгдсэн.	2021 онд Мэдээллийн сангийн үйл ажиллагааг эхлүүлэх; 2022 онд Спортын цол олгох ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болох 2023 онд Сорилын ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болох; 2024 онд Спортын тэмцээн, наадмын ажил, үйлчилгээг цахимаар үзүүлдэг болох.	Улсын төсөв 700.0 сая төгрөг

	<p>Арга хэмжээ 4. Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгоно.</p>	<p>Гэрээний дагуу шилжүүлсэн ажлын тоо</p>	<p>-</p>	<p>2021 онд 77 ажил; 2022 онд 86 ажил; 2023 онд 96 ажил; 2023 онд 106 ажил.</p>	<p>Улсын төсөв 1,850.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 5. Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлэх, насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагаа статик, динамик байдал цахим хэлбэрээр богино хугацаанд авч, иргэдэд насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөрт суурилсан арга зүйн зөвлөмж өгдөг болох</p>	<p>2020 онд судалгаа хийгдсэн бөгөөд сорил авах 2 хувилбарын төслийг боловсруулсан.</p>	<p>2021 онд Сорилыг цахим хэлбэрээр авах техник, хэрэгслээр аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагыг хангах; 2022 онд Иргэдэд насны бүлэг, ажил, амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хөтөлбөрийг боловсруулах; 2023 онд Цахимд суурилсан иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үйл ажиллагаа салбарын хэмжээнд бүрэн хэрэгжих; 2024 онд Бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнгээр идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх зөвлөмжийг цахим хэлбэрээр иргэдэд үзүүлдэг болох.</p>	<p>Улсын төсөв 1,800.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 6. Иргэд эрүүл, аюулгүй орчинд, өөрийн бие бялдарт тохирсон арга зүйн дагуу спортоор хичээллэх нөхцөлийг спортын сургалт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандарт, түүнийг хэрэгжүүлэх спортын сургалтын жишиг хөтөлбөрөөр бүрдүүлэх, стандарт, хөтөлбөрийг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Иргэдийг спортоор хичээллэхэд эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх талаар батлуулах стандарт болон хувь стандартыг хэрэгжүүлэх жишиг сургалтын хөтөлбөрийн тоо</p>	<p>2020 онд батлуулсан стандарт 13, боловсруулсан хөтөлбөрийн төсөл 2</p>	<p>2021 онд 6 спортын төрлийн стандарт, 2 сургалтын хөтөлбөр; 2022 онд 6 спортын төрлийн стандарт, 2 сургалтын хөтөлбөр; 2023 онд 6 спортын төрлийн стандарт, 2 сургалтын хөтөлбөр; 2024 онд 6 спортын төрлийн стандарт, 2 сургалтын хөтөлбөр.</p>	<p>Улсын төсөв 160.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 7. Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ.</p>	<p>Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санд мэдээлэл байршуулах төрийн байгууллага, спортын холбоодын тоо</p>	<p>-</p>	<p>2021 онд 15 спортын холбоо, 30 спортын төрийн байгууллага; 2022 онд 15 спортын холбоо; 2023 онд 20 спортын холбоо; 2024 онд 20 спортын холбоо.</p>	<p>Улсын төсөв 1,000.0 сая төгрөг</p>

	Арга хэмжээ 8. Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох, мэргэшүүлэх давтан сургалтыг зохион байгуулна.	Мэргэшүүлэх давтан сургалтад хамруулах биеийн тамирын арга зүйчийн тоо	-	2021 онд сургалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулах; 2022 онд 60 арга зүйч; 2023 онд 50 арга зүйч; 2024 онд 90 арга зүйч.	Улсын төсөв 400.0 сая төгрөг
Зорилт 2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.	Арга хэмжээ 1. Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	ТЭЗҮ-ийг боловсруулж байна.	2022 онд Барилга угсралтын ажлыг эхлүүлэх; 2023 онд 70 хувь; 2024 онд 100 хувь.	Улсын төсөв 80,000.0 сая төгрөг
	Арга хэмжээ 2. Спортын төв ордон барих ажлыг эхлүүлнэ.	Санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэсэн байх	Схем зураг хийгдсэн.	2021 онд ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах; 2022 онд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх.	БНХАУ-ын буцалтгүй тусламж
	Арга хэмжээ 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолборыг ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	Зураг төсөв хийгдэж, газрын асуудал шийдвэрлэгдсэн.	2021 онд 27 хувь; 2022 онд 73 хувь; 2023 онд 95 хувь; 2024 онд 100 хувь.	БНХАУ-ын буцалтгүй тусламж 54,700.0 сая төгрөг
	Арга хэмжээ 4. Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг барьж ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	Зураг төсөв хийгдэж, газрын асуудал шийдвэрлэгдсэн.	2022 онд 27 хувь; 2023 онд 67 хувь; 2024 онд 100 хувь.	Улсын төсөв 7,400.0 сая төгрөг
	Арга хэмжээ 5. Нийслэлийн болон Налайх, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар дүүргийн иргэдэд үйлчлэх усан бассейн бүхий спортын цогцолборын ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	-	2021 онд Баянгол дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулах; 2022 онд Баянзүрх, Налайх дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулах; 2023 онд Нийслэлийн болон Сүхбаатар дүүргийн усан бассейн бүхий спортын цогцолборыг ашиглалтад оруулах.	Улсын төсөв 10,200.0 сая төгрөг
	Арга хэмжээ 6. Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар аймгуудад шинээр спортын цогцолбор барина.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	Нэг хэв маягийн зураг төсөв хийгдэж, газрын асуудал шийдвэрлэгдсэн.	2022 онд Говьсүмбэр аймгийн спортын цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх; 2023 онд Дундговь, Сүхбаатар аймгийн спортын цогцолборын барилгын ажлыг эхлүүлэх.	Улсын төсөв 25,306.5 сая төгрөг

	Арга хэмжээ 7. Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв байгуулна.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	Зураг төсөв хийгдэж, газрын асуудал шийдвэрлэгдсэн.	2022 онд 40 хувь; 2023 онд 100 хувь.	Улсын төсөв 7,400.0 сая төгрөг
	Арга хэмжээ 8. Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.	Зураг төсөл боловсруулах, ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байх	-	2021 онд батлуулах.	Улсын төсөв 83.7 сая төгрөг
Үндсэн чиг үүрэг-2: Спортын сургалт-дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх					
Зорилт 3. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.	Арга хэмжээ 1. Үндэсний уламжлалт спортын төв байгуулж, үндэсний багтай болно.	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	-	2021 онд ТЭЗҮ-ийг боловсруулах; 2022 онд ажлыг эхлүүлэх; 2023 онд 100 хувь; 2024 онд ашиглалтад оруулах.	Улсын төсөв 2,000.0 сая төгрөг
	Арга хэмжээ 2. Улсын хэмжээнд иргэдийн дунд нийтийн спортын төрөлжсөн наадмыг 2-4 жил тутамд зохион байгуулна.	Иргэдийн наадам зохиогдсон байх	-	2021 онд Иргэдийн наадмын спортын төрлийг тогтоох, бэлтгэл ажлыг хангах; 2022 онд Иргэдийн наадам зохион байгуулах.	Улсын төсөв 1,200.0 сая төгрөг
	Арга хэмжээ 3. Үндэсний уламжлалт спортоор олон улсын спортын наадмын брэнд бий болгоно.	Олон улсын үндэсний спортын наадам зохиогдсон байх	ЮНЕСКО-гийн Уламжлалт спорт, тоглоом наадгайн олон улсын зөвлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан.	2021 онд зохион байгуулах шийдвэр гаргуулах; 2022 онд спортын төрлүүдийг тогтоох, бэлтгэл ажлыг эхлүүлэх; 2023 онд бэлтгэл ажлыг хангах; 2024 онд зохион байгуулах.	Улсын төсөв 1,950.0 сая төгрөг
	Арга хэмжээ 4. Үндэсний уламжлалт спортын холбоодын хөгжлийг дэмжиж, хэрэглэл материалаар хангана.	Үндэсний спортын хөгжлийг тогтмолжуулах хувь болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх хувь	50 хувь	2021 онд 55 хувь; 2022 онд 60 хувь; 2023 онд 70 хувь; 2024 онд 80 хувьд тогтмолжуулах. Хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,360.0 сая төгрөг
	Арга хэмжээ 5. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлан таниулж, өвлөн уламжлуулах ажлыг зохион байгуулна.	Үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд сурталчлах түүхэн контентийн тоо	-	2021-2024 онд жил бүр 4 контент.	Улсын төсөв 800 сая төгрөг

Зорилт 4. Спортын сургалт-дасгалжуулалтын, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулна.	Арга хэмжээ 1. Үндэсний шигшээ багийн залгамж халааг сайжруулж, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх Залуучуудын шигшээ багийн спортын төрлийг нэмэгдүүлнэ.	Залуучуудын шигшээ баг байгуулах спортын төрлийн тоо	-	2023 онд 4 спортын төрөл; 2024 онд 6 спортын төрөл.	Улсын төсөв 3,000.0 сая төгрөг
	Арга хэмжээ 2. Спортын цол олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулж хялбаршуулна.	Тамирчдын спортын цолны лавлагааг цахимаар олгох боломжтой болсон байх	-	2022 онд E-Mongolia цахим үйлчилгээний нэгдсэн сангаас лавлагаа авах ажлыг эхлүүлэх.	Улсын төсөв 100 сая төгрөг
	Арга хэмжээ 3. Спортын амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчдад мөнгөн шагнал олгож, олимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль авсан тамирчдад сар бүр урамшуулал олгоно.	Урамшуулал олгосон тамирчин, дасгалжуулагчийн тоо	1573 тамирчин, дасгалжуулагч	1573 тамирчин, дасгалжуулагч.	Улсын төсөв 12,000.0 сая төгрөг
	Арга хэмжээ 4. Сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулна.	Улсын хэмжээнд мэргэшүүлэх сургалтад хамруулах дасгалжуулагчийн тоо	-	2021 онд 60; 2022 онд 60; 2023 онд 80; 2024 онд 80.	Улсын төсөв 400.0 сая төгрөг
	Арга хэмжээ 5. Үндэсний шигшээ багийн спортын төрөл, тамирчин сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Дараагийн олимпын мөчлөгт бэлтгэх үндэсний шигшээ багийг бүрдүүлсэн байх	Зуны олимпын спортын 12, өвлийн олимпын спортын 3, зуны паралимпын 6, өвлийн паралимпын 1, нийт 22 спортын төрөлд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан.	2021 онд зуны спортын төрөлд сонгон шалгаруулалтыг зохион байгуулах; 2022 онд өвлийн спортын төрөлд сонгон шалгаруулалтыг зохион байгуулах.	Улсын төсөв 32,000.0 сая төгрөг
	Арга хэмжээ 6. Хүүхэд, залуучуудын спортын авьяасыг илрүүлж шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх хүрээнд үндэсний хэмжээнд спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг жил тутам зохион явуулж, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	Хүүхдийн спортын наадам, Оюутны спортын наадмыг зохион байгуулсан байх	-	2 жил тутамд зохион байгуулах.	Улсын төсөв 2,800.0 сая төгрөг

	<p>Арга хэмжээ 7. Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийх болон өсвөр үеийн шигшээ багт хүрч ажиллах дэд бүтцийг сайжруулна.</p>	<p>Спортын дасгалжуулалтын шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлж, судалгаа шинжилгээ хийх суурь нөхцөл бүрдсэн байх</p>	<p>21 аймаг, 9 дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн сургалт-дасгалжуулалтыг тогтмол хянах, зөвлөмж, дүгнэлт өгөх цахим платформ бий болсон.</p>	<p>2021 онд өсвөр үеийн шигшээ багийн тамирчдаас түүвэр судалгаа, сорил авах, дасгалжуулагчдын сургалт-дасгалжуулалтын арга зүйд дүн шинжилгээ хийх; 2022 онд тамирчдын дасгалжуулалтын түвшинг давтамжтай тодорхойлох цахим платформ бий болгох; 2023 онд шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх үйл ажиллагааны дунд болон урт хугацааны төлөвлөлтийг боловсруулах; 2024 онд шилдэг тамирчдын залгамж халаа бэлтгэх сургалт-дасгалжуулалтын тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>Улсын төсөв 2,000.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 8. Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багт үзүүлэх спортын анагаах ухааны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Оношилгоо, эмчилгээний суурь түвшинг нэмэгдүүлэх хувь</p>	<p>2020 онд давхардсан тоогоор 13764 тамирчин</p>	<p>2021 онд 10 хувь; 2022 онд 15 хувь; 2023 онд 20 хувь; 2024 онд 25 хувиар нэмэгдүүлэх.</p>	<p>Улсын төсөв 3,000.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 9. Спортын холбоодын урт хугацааны бодлого төлөвлөлтийг боловсруулна.</p>	<p>Урт хугацааны бодлого төлөвлөлт боловсруулах спортын холбооны тоо</p>	<p>-</p>	<p>2021-2024 онд жил бүр 5 спортын холбоо.</p>	<p>Улсын төсөв, төслийн санхүүжилт</p>
	<p>Арга хэмжээ 10. Шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Улсын хэмжээнд шинэ тутам хөгжиж буй спортын төрлийн хамрах хүрээ (хувиар)</p>	<p>-</p>	<p>2021 онд 5 хувь; 2022 онд 15 хувь; 2023 онд 25 хувь; 2024 онд 35 хувь.</p>	<p>Улсын төсөв 4,000.0 сая төгрөг</p>
	<p>Арга хэмжээ 11. Өвлийн спортын төрлийг орон нутгийн түвшинд хамрах хүрээг тэлж, хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Өвлийн спортын хөгжлийг тогтмолжуулах хувь болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх хувь</p>	<p>15 хувь</p>	<p>2021 онд 18 хувь; 2022 онд 20 хувь; 2023 онд 30 хувь; 2024 онд 40 хувьд тогтмолжуулах. Хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх.</p>	<p>Улсын төсөв 1,540.0 сая төгрөг</p>

	Арга хэмжээ 12. Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний хүн амд үзүүлэх нэр төрлийг багийн спортын төрлөөр нэмэгдүүлж, орон нутагт хамрах хүрээг тэлнэ.	Багийн спортын төрлийг нэмэгдүүлэх хувь болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх хувь	60 хувь	2021 онд 5 хувь; 2022 онд 5 хувь; 2023 онд 10 хувь; 2024 онд 10 хувь тогтмолжуулах. Хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,800.0 сая төгрөг
	Арга хэмжээ 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулж, дэмжлэг үзүүлэн хэрэглэл материалаар хангана.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын үйл ажиллагаа болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх хувь	10 хувь	2021 онд 5 хувь; 2022 онд 5 хувь; 2023 онд 10 хувь; 2024 онд 10 хувь тогтмолжуулах. Хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,050.0 сая төгрөг
	Арга хэмжээ 14. Ахмад настнуудыг спортын үйл ажиллагаанд хамруулж, дэмжлэг үзүүлэн хэрэглэл материалаар хангана.	Ахмад настнуудын спортын үйл ажиллагаанд хамрагдалтын хувь болон хэрэглэл материалыг нэмэгдүүлэх хувь	70 хувь	2021 онд 75 хувь 2022 онд 80 хувь 2023 онд 85 хувь 2024 онд 90 хувь тогтмолжуулах. Хэрэглэл материалыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэх.	Улсын төсөв 1,050.0 сая төгрөг

Үндсэн чиг үүрэг-3: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт 5. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангана.	Арга хэмжээ 1. Салбарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хууль, журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	Тухай жилийн салбарын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	-	-	-
	Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын хүрээнд батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.	Тухай жилийн салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ	-	-	-
	Арга хэмжээ 3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлж, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлэх сургалтад хамруулна.	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо	-	-	-

	Арга хэмжээ 4. Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, бодлого төлөвлөлтийг сайжруулна.	Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангахад салбарын байгууллагын уялдаа, төлөвлөлт сайжирсан байх	-	Салбарын 30 төрийн байгууллага бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй болох.	-
	Арга хэмжээ 5. Салбарын бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулна.	Салбарын бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан байх	2020 онд Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, Үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.	Салбарын бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах.	-
Зорилт 6. Төвлөрүүлэн захирагчийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, зохицуулалтаар хангах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах	Арга хэмжээ 1. Биеийн тамир, спортын салбарын урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулна.	Тухай жилийн улсын болон орон нутгийн батлагдсан төсөв	2020 онд батлагдсан төсөв 28.4 тэрбум төгрөг	-	-
Зорилт 7. Биеийн тамир, спортын салбар болон агентлагийн гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх	Арга хэмжээ 1. Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад улсын Засгийн газар болон бусад ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагааны баримт бичиг байгуулж, хэрэгжилтийг хангана.	Биеийн тамир, спортын чиглэлээр гадаад улсын Засгийн газар болон бусад ижил төстэй байгууллагуудтай байгуулах хамтын ажиллагааны баримт бичгийн тоо	2020 онд Засгийн газар хоорондын 5 баримт бичиг, ижил түвшний байгууллагатай 11 баримт бичиг байгуулсан.	2021-2024 онд жил бүр 1 хамтын ажиллагааны баримт бичиг.	-
	Арга хэмжээ 2. Олон улсын байгууллагаас баталсан баримт бичгийн хэрэгжилтийг хангана.	Олон улсын байгууллагаас баталсан 2 баримт бичигт туссан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулж, тайланг хүргүүлсэн байх	-	2021, 2023 онд ЮНЕСКО-гийн спорт дахь допингийн эсрэг конвенцын хэрэгжилтийг тайланг хүргүүлэх; 2022 онд биеийн бялдрын боловсрол, идэвхтэй хөдөлгөөн, спортын олон улсын харти хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлэх.	-

	Арга хэмжээ 3. Биеийн тамир, спортын дотоод, гадаадын албаны төлөөлөгчдийн албан айлчлалыг зохион байгуулна.	Биеийн тамир, спортын дотоод, гадаадын албан айлчлалыг зохион байгуулсан байх	-	2021 онд Токио-2020 зуны олимп, паралимпын наадамд албаны төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулах; 2022 онд Бээжин-2022 өвлийн олимп, паралимпын наадамд албаны төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулах; 2023-2024 онд Парис-2024 зуны олимп паралимпын наадамд Монгол Улсын багийг оролцуулахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, албаны төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулах.	Улсын төсөв 200.0 сая төгрөг
Зорилт 8. Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж, дүгнэлтээр хангах, хяналт тавих	Арга хэмжээ 1. Биеийн тамир, спортын салбарын байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмж, дүгнэлтээр ханган хяналт тавина.	Орон нутгийн биеийн тамир, спортын байгууллага, холбоодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлтээр хангасан байх	-	2021 онд 10 төрийн байгууллага; 2022 онд 21 төрийн байгууллага; 2023 онд 35 спортын холбоо; 2024 онд 35 спортын холбооны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Улсын төсөв 720.0 сая. төгрөг
	Арга хэмжээ 2. Биеийн тамир, спортын салбарын бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, зөвлөмж, дүгнэлтээр ханган хяналт тавина.	Биеийн тамир, спортын салбарын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх, зөвлөмж, дүгнэлтээр хангасан байх	-	2021 онд Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийх; 2022 онд Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогын I үе шатны хэрэгжилтэд үнэлгээ хийх; 2023 онд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээ хийх; 2024 Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх.	-
Зорилт 9. Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэн сайжруулах	Арга хэмжээ 1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийнэ.	Эрсдэлд суурилсан төлөвлөгөөт аудит, хяналт шалгалтыг хийсэн байх	-	2021 онд 15 байгууллага; 2022 онд 19 төрийн байгууллага; 2023 онд 19 спортын холбоо; 2024 онд 11 спортын холбоонд аудит, хяналт шалгалт хийх.	Улсын төсөв 950.0 сая төгрөг

-----oOo-----